



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№82 /295/ 2022.04.28

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ ЦЭРГИЙН СҮР ХҮЧ, СҮЛД ХИЙМОРЬ БОЛСОН АЛТАН МӨРДЭСТНҮҮДДЭЭ “МОНГОЛ ГЕНЕРАЛЫН ӨДӨР”-ИЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!

МЭНДЧИЛГЭЭ



Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь болсон алтан мөрдөстнүүддээ “Монгол генералын өдөр”-ийн баярын мэндчилгээг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа өргөн дэвшүүлж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Монгол Улсад генерал хэмээх эрхэм цолыг олгож, хэрэглэж эхэлсээр өдгөө 78 дахь жил энэ онд тохиож байна.

БНМАУ-ын Ардын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор анх генерал цол олгож эхэлсэн энэ өдрийг эх орныхоо халдашгүй дархан байдлын төлөө тангараг өргөн зүтгэсэн цэргийн дээд цолтнуудынхаа үйл хэрэг, эх орныхоо өмнө байгуулсан алдар гавьяаг мөнхжүүлэн, хүндэтгэл үзүүлэх, бахархан дуурайх үзлийг хойч үедээ төлөвшүүлэх, тэдний цэргийн хэргийн өргөн мэдлэг, цэрэг амьдралын баялаг туршлагаас суралцах явдлыг эрхэм болгож ирсэн билээ.

Эрхэм генералууд маань үеийн үед, цагийн цагт туурга тусгаар Монгол Улсынхаа бүрэн эрхт байдлыг сахин хамгаалж, туг сүлд нь босоо залаат үндэс язгуураа мандуулан бадраах их үйлсийн тэргүүн эгнээнд манлайлан, хүн ардынхаа амар амгалангийн төлөө нэгэн насны хөдөлмөр зүтгэлээ зориулсаар ирсэн гавьяатайг түүхийн энэ өдөр тэмдэглэхэд таатай байна.

“Байлдагчийн халаасанд генералын мөрдэс бий” гэж манай цэргийнхэн ярьдаг. Үнэхээр ч нэгэн үзүүрт сэтгэлээр төр, улсынхаа төлөө зүтгэсэн мянга мянган цэрэг эрсийн

дундаас уйгагүй хөдөлмөр, хичээл зүтгэл, өөртөө тавьсан өндөр зарчимч шаардлага, үйл хэргээрээ шалгарсан шилдэг хөвгүүдээ Монгол төр үнэлж, генералын алтан мөрдсийг соёрхон олгодог билээ. Дэлхийн түүхэнд нэр, алдраа мөнхөлсөн хурц ухаантай, эрэлхэг зоригтой, баатарлаг цэргийн аугаа жанжид Монголын түүхнээ цөөнгүй тодрон гарсан юм. Цэргийн түүх, цэргийн урлаг судлаач дэлхийн шилдэг эрдэмтэд өнөөдөр ч Монгол жанждын суут ухаан, цэрэг засах, захирах, байлдах урлагийг шимтэн судалж, зохиол бүтээлдээ тусгаж, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололт дэвшилтэй хослуулан, стратеги судлалыг гүнзгий хөгжүүлэн улам боловсронгуй болгосоор байгаа нь бидний өвөг дээдсийнхээ суу алдраар бахархах үзлийг хөгжүүлж, “Би Монгол хүн” гэх омогшлыг үргэлж бадрааж байдаг. Өвөг дээдэс, ахмад үеийнхээ үйл хэргийг нэр төртэй залгамжилж өдгөө ч манай эрхэм генералууд өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад албаа нэр төртэй хааж, Монгол төрийн батлан хамгаалах бодлого, зорилт, үйл ажиллагааны

түшиг тулгуур, хөдөлгөгч хүч нь байсаар байна.

Өнөө жил “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан алтан мөрдөстнүүдийн эгнээг тэлж ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга хурандаа Г.Болор Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бригадын генерал цол хүртсэн. Монгол Улс түүхэндээ анх удаа эмэгтэй генералтай болсон нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг баталгаажуулах, Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хэрэгжүүлэх, даян дэлхийд энх тайвныг тогтооход эмэгтэй цэргийн алба хаагчдын оруулж буй хувь нэмрийг төр, засаг өндөрөөр үнэлсний нэгэн тод илрэл хэмээн үзэх учиртай.

Эх орон, төр, ард түмнийхээ итгэл, хүндлэлийг хүлээж, улс Монголынхоо халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах үйл хэргийн манлай болсон эр цэргийн хийморь, эрхэм генералууд Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТА БҮХНИЙГ МОНГОЛ ЦЭРГИЙН ДОГШИН ИХ ХАР СҮЛД ҮРГЭЛЖ ИВЭЭЖ БАЙХ БОЛТУГАЙ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

Монгол Улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил дэвшилд залуу нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан бэлтгэл, чөлөөнд байгаа генералууд, өдгөө төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын өндөр хариуцлагатай албанд амжилт дүүрэн зүтгэж буй эрхэм генералууд Та бүхэнд “Монгол генералын өдөр”-ийн баярын мэндийг дэвшүүлье!

БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор анхны 11 хүнд генерал цолыг анхлан олгосон бөгөөд 2004 оноос тэрхүү өдрийг “Монгол генералын өдөр” болгон тэмдэглэж ирсэн билээ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

Энэхүү баярын өдөр нь алтан мөрдэст генералуудынхаа ажил, амьдралын туршлага, сургамж, амжилт ололт, алдар гавьяа, хөдөлмөр зүтгэл, бүтээлч үйл ажиллагаа, дайчин уламжлалыг нь сурталчлах, хойч үеийнхэнд өвлүүлэх, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх өндөр ач холбогдолтой юм.

Монгол эх орон, төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарага үнэнчээр биелүүлэн, мэргэжил, дадлага, туршлага, ур чадвар, авьяас билгээрээ ямагт үлгэрлэн манлайлж ирсэн эрхэм генералууд Та бүхнийхээ цаашдын ажил үйлсэд арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе!



"МОНГОЛ ГЕНЕРАЛЫН ӨДӨР"-Т ..



Өдгөөгөөс 78 жилийн өмнө буюу 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр БНМАУ-ын Ардын сайд нарын Зөвлөлийн тогтоолоор цэргийн гарамгай 11 зүтгэлтэнд “Генерал” хэмээх цэргийн дээд цолыг анх удаа олгосноос хойш жил бүрийн энэ өдрийг алтан мөрдөстнүүдийн өдөр болгон тэмдэглэж ирсэн түүхтэй. Жил бүрийн энэ өдөр төрийн цэрэг болон хууль сахиулах байгууллагаас алтан мөрдөстнүүддээ ээлжлэн хүлээн авч, хүндэтгэл үзүүлж ирсэн уламжлалтай бөгөөд энэ жил Төрийн тусгай хамгаалалтын газраас хариуцан ажиллаж байгаа юм.

Энэхүү түүхэн өдрийг 2004 оноос хойш “Монгол генералын өдөр” болгон тэмдэглэхдээ алтан мөрдэст генералуудаараа бахархах, тэдний гавьяа зүтгэл, дайчин уламжлалыг нь хойч үеийнхэнд өвлүүлэх, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх өндөр ач холбогдолтой юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
6	-10


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,105.00	3,155.0
EUR	3,385.0	3,410.0
CNY	476.00	482.00
RUB	37.40	38.00
JPY	24.20	25.50
KRW	2.51	2.58

ЗУРХАЙ





2022.04.28 ПҮРЭВ ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 28/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ
САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ЦАГААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
05.40-20.00
Барилдлага:
Үл зохицох
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй
Суудал: Огторгуй

Энэ өдөр туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатагахад сайн. Газар ухах, цудаг гаргах, уул овоо тахилах муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,272,84 /69.9%/	2,175,35 /66.9%/	1,037,670 31,9%
		120,959 /3,7%/
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8459 +112	8	8321

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 511,394,793

Эдгэрсэн

Нийт: 464,694,642

Нас барсан

Нийт: 6,253,036

Цахим шууданд

БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДААС СУРТАЛЧЛАХ АЯН ЭХЭЛЛЭЭ



хуваариар долоо хоногийн хугацаанд сурталчлах бөгөөд удирдамжид заасны дагуу анги, байгууллагын товч танилцуулгыг хийж, танин мэдэхүй, спортын болон бусад уралдаан тэмцээнийг зохион байгуулж, тус бүр нэг бүтээлч ажлыг өрнүүлнэ.

Уг аяны нээлттэй уялдуулан энэ удаа Батлан хамгаалах яам, Цэргийн төв эмнэлэг, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн дуу

сурталчиллаа. Энэ үеэр дээрх байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилсан танилцуулгыг дүрс бичлэгээр хүргэж, оюун ухаан, танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хууль болон түүхэн, хөгжөөнт, чөлөөт сэдвийн хүрээнд зохион байгуулсан юм. Тус тэмцээний тэргүүн байрт хуягт тээвэрлэгчийн ротын буудагч дэд ахлагч Э.Дүүрэнбэлэг, дэд байрт холбооны офицерын туслах



БНӨСҮ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах UN-MISS ажиллагааны 11 дүгээр ээлжид үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах төлөвлөгөө, батлагдсан хуваарийн дагуу нэгтгэл, анги, байгууллагуудыг сурталчлах аяныг 2022 оны дөрөвдүгээр сарын 18-ны өдрөөс эхлүүлнэ.

Уг аяныг нээж мотобуудлагын батальоны захирагч хурандаа О.Заяат хэлсэн үгэндээ "Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй бид бүхэн өөрсдийн нэгтгэл, анги,

байгууллагыг сурталчлан таниулах нь олон талын ач холбогдолтой бөгөөд энэхүү бүтээлч ажлын хүрээнд бие бүрэлдэхүүний хамт олонч, нөхөрсөг уур амьсгал бүрдэж, тэдний чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, харилцан туршлага солилцоход дэмжлэг үзүүлдэг. Тиймээс энэхүү ажилд бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцохыг уриалж байна" гэдгийг онцлоод нийт офицер, ахлагч нарт амжилт хүслээ.

Энэхүү аяны хүрээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудыг төлөөлж ирсэн цэргийн алба хаагчид үйл ажиллагаагаа батлагдсан



бүжгийн эрдмийн чуулгын цэргийн алба хаагчид байгууллага, хамт олноо

ахмад М.Болд-Эрдэнэ, гутгаар байрт хангалт үйлчилгээний ротын тээврийн

салааны орлогч ахлах ахлагч У.Ганбаатар нар шалгарсан юм.

Харин хөгжөөнт, цэнгээнт "Fun day" тэмцээнд хангалт үйлчилгээний ротын "Гарын 5 хуруу" баг, 3 дугаар мотобуудлагын ротын "Яг яана гээд байгаа юм бэ?" баг, байлдааны хангалтын ротын "Симба-11" баг эхний байрт шалгарсан амжилтыг үзүүллээ.

Мөн энэ үеэр эмч нарын бүлгээс үзүүл мэндийн нээлттэй үзлэгийг явуулж зөвлөгөө өгсөн ба мотобуудлагын батальоны номын санд Цэргийн дуу

бүжгийн эрдмийн чуулгын шинэ номын бүтээлүүдээс дурсгалаа.

Тэрчлэн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудыг сурталчлах аяны удирдамжийн дагуу мотобуудлагын батальоны харуулын байрын амрах өрөөг шинэчлэн засварласны үр дүнд харуулын үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдын тав тухтай байх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн бүтээлч ажил боллоо.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Тус ангиас 2022 онд цэргийн тэтгэвэрт гарсан бэлтгэл офицер ахлагч нарыг ангийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх мөн цэргийн тангараг давтах ажиллагааг энэ сарын 15-ны өдөр зохион байгуулан

явууллаа.

Энэ үеэр ангийн захирагч хурандаа Г.Чулуунзагд бэлтгэл офицер ахлагч нарт хандан үг хэлж, дурсгалын зүйл гардууллаа. Мөн тус ангиас цэргийн тэтгэвэрт гарсан бэлтгэл офицер ахлагч нар хамт олондоо амжилт хүсэж, өнгөт принтер бэлэглэлээ. Түүнчлэн "Өрнөх

хөгжил" ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн, УИХ-ын гишүүн Ц.Цэрэнлунцагийн бие төлөөлөгч Д.Батцэцэг "Нийгмийн хариуцлага", "Улсын төсвийн хөрөнгө оруулалт", "Орон нутгийн бэлтгэл офицер ахлагч бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгууллаа.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО



Н.Тэмүүжин захирагчтай тасаг; 3-р байранд ахлах зургаадугаар сургуулийн сурагч Н.Амарбаясгалан захирагчтай тасаг; тусгай байруудад Улсын тэргүүний цогцолбор хоёрдугаар сургуулийн сурагч Т.Ганзориг захирагчтай тасаг; Зүүнговь сумын ахлах сургуулийн сурагч Д.Нансалжав захирагчтай тасууд шалгарч шагналыг аймгийн Засаг дарга Ч.Чимэд, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Тогтохбаяр, БШУГ-ын дарга А.Болормаа нар гардуулж баяр хүргэлээ.

Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Өсвөр үе хүүхэд, залуучуудад цэрэг-эх орон үзэл төлөвшүүлэх томоохон арга хэмжээ болох "ДӨЛ" цогцолбор тэмцээнд ерөнхий боловсролын сургуулиудаас шалгарсан 10 багийн 110 сурагч оюун ухаан, хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр хатуужил, авьяас чадвараа сөрөн 2 өдрийн турш өрсөлдөж дүнгээ гаргалаа. 1-р байранд Улсын тэргүүний цогцолбор нэгдүгээр сургуулийн сурагч Ц.Мөнгөнбаяр захирагчтай тасаг; 2-р байранд ахлах гуравдугаар сургуулийн сурагч

